



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2010 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 381

Улаанбаатар хот

Хөдөө орон нутагт эмнэлгийн мэргэжилтэн
томилолтоор ажиллуулж, ажлын байрны сургалт
зохион байгуулах тухай


Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн асуудлаарх салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн 2008 оны 03 тоот тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2010 оны 169 дүгээр тушаал, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөө орон нутагт 2010 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 2011 оны 02 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл 3 сарын хугацаагаар ажиллаж, ажлын байрны сургалт хийх эмнэлгийн мэргэжилтний хуваарийг хавсралтаар баталсугай.
2. Хуваарилагдсан эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажиллах нөхцлийг хангаж, цалин болон бусад нэмэгдлийг Засгийн газрын 2010 оны 239 тоот тогтоолын дагуу тооцож олгохыг эмнэлгийн мэргэжилтэн ажиллуулж буй аймгийн эрүүл мэндийн газрын дарга нарт, сар бүр урамшуулал олгохыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газрын дарга Ц.Содномпил нарт тус тус үүрэг болгосугай.
3. Эмнэлгийн мэргэжилтнүүдийг орон нутагт гэрээгээр ажиллах хугацаанд үндсэн байгууллага нь ажлаас түр чөлөөлж, гэрээний хугацаа дуусгавар болсны дараа ажлын байранд нь эргүүлэн авах, тухайн хугацаанд хөдөө орон нутгаас сэлгэн ажиллах эмч, мэргэжилтнүүдийн ажлын байр, цалин хөлсний асуудлыг шийдвэрлэж ажиллуулахыг ШТЭ-ийн дарга Б.Батчулуун, ЭНЭШТ-ийн захирал Т. Эрхэмбаатар нарт даалгасугай.
4. Тушаал, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Баярт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газрын дарга Ц.Содномпил нарт даалгасугай.



САЙД

С.ЛАМБАА



Эрүүл мэндийн сайдын 2010 оны
10 дугаар сарын 29 өдрийн 581 тоот
тушаалын хавсралт

	Овог нэр	Одоо ажиллаж байгаа ажлын хаяг, мэргэжил, зэрэг	Гэрээгээр ажиллах аймаг
1.	П. Чулуунцэцэг	ШТЭ. мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тэргүүлэх зэргийн их эмч	Говь-Алтай
2.	Г. Баяраа	ШТЭ. Мэс заслын эмч, АУ-ны доктор	Говь-Алтай
3.	Р. Нуржанар	ЭНЭШТ. Хүүхдийн мэс заслын тэргүүлэх зэргийн их эмч	Увс
4.	Х. Сувд-Эрдэнэ	ЭНЭШТ.мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний ахлах зэргийн сувилагч	Увс
5.	Л. Хорлоо	ЭНЭШТ мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний ахлах зэргийн их эмч	Өмнөговь
6.	Ч. Мөнхбаяр	ЭНЭШТ. Эх барих эмэгтэйчүүдийн ахлах зэргийн их эмч	Өмнөговь
7.	Б. Бэрцэцэг	ЭНЭШТ мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний ахлах зэргийн сувилагч	Өмнөговь

ОРОН НУТАГТ АЖИЛЛАХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНТЭЙ ХИЙХ ГЭРЭЭ

Нэг. Ерөнхий зүйл.

1.1 Энэхүү гэрээг нэг талаас Эрүүл Мэндийн Яам /цаашид ЭМЯ гэх/, аймгийн Засаг дарга, аймгийн Эрүүл мэндийн газар /цаашид Эрүүл мэндийн газар гэх/ нөгөө талаас төв /эмнэлэгт ажиллаж буй тоот иргэний үнэмлэх,регистрийн дугаартайовогтой-г аймгийн нэгдсэн эмнэлэгтэмчийн/сувилагчийн мэргэжлээр ажиллуулахаар харилцан тохиролцож 2010 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 2011 оны 02 дугаар сарын 05 -ны өдөр хүртэл 3 сарын хугацаатай байгуулав.

1.2 Энэхүү гэрээ нь Эрүүл мэндийн яам, аймгийн Засаг дарга, аймгийн эрүүл мэндийн газар, эмнэлгийн мэргэжилтэн /цаашид “талууд” гэх/ хоорондын хөдөлмөрийн харилцааг энэхүү гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулна.

Хоёр. Гэрээний зорилго

2.1 Эмнэлгийн мэргэжилтэнд урамшуулал олгон ажиллуулах замаар орон нутгийг төрөлжсөн мэргэжлийн эмчээр ханган, орон нутагт ажиллаж буй мэргэжилтний чадавхийг бэхжүүлэх, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, төгсөлтийн дараах сургалт явуулахад гэрээний зорилго оршино.

Гурав. Гэрээний үндсэн нөхцөл

3.1 Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэж, төгсөлтийн дараах сургалтыг орон нутагт чанартай хийж сар бүр урамшуулал авч ажиллахыг талууд харилцан тохиролцов.

Дөрөв. Эрүүл мэндийн яамны эрх, үүрэг

4.1 Эмнэлгийн мэргэжилтний ажлын нөхцөл, орон байрны талаарх асуудлаар талуудад шаардлага тавина.

4.3 Энэхүү гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллана.

Тав. Аймгийн Засаг даргын эрх, үүрэг

5.1 Эмнэлгийн мэргэжилтнийг ажлын нөхцөл, орон байраар хангаж, шаардлагатай нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

5.2 Хуваарилагдан ажилласан эмнэлгийн мэргэжилтний ажлыг эрүүл мэндийн газартай хамтран гэрээний хугацаа дууссаны дараа 14 хоногт багтаан дүгнэж, 2011 оны 2 дугаар сарын 25-ны дотор Эрүүл мэндийн яаманд ирүүлнэ.

Зургаа. Аймгийн эрүүл мэндийн газрын эрх, үүрэг

6.1 Эмнэлгийн мэргэжилтнийг орон нутагт ирэх буцах замын зардал, орон байраар хангах асуудлыг орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран шийднэ.

6.2 Эмнэлгийн мэргэжилтэнд тухайн орон тооны үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг үндсэн ажилтны адил тооцож олгоно.

6.3 Эмнэлгийн мэргэжилтнийг орон нутагт төрөлжсөн мэргэжил эзэмшүүлэх сургалт явуулахад дэмжлэг үзүүлж, сургалтын нөхцлөөр хангана.

6.4 Орон нутагт ажиллахаар ирсэн эмнэлгийн мэргэжилтний оронд төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг/төвүүдэд солилцоогоор ажиллуулах эмнэлгийн мэргэжилтнийг томилж, хяналт тавьж ажиллана.

6.5 Эмнэлгийн мэргэжилтнийг үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

6.6 Эмнэлгийн мэргэжилтнийг ажиллах хугацаанд тухайн мэргэжлээр ажиллах үндсэн мэргэжилтнийг ажлын байран дээр бэлтгэх үйл ажиллагааг удирдлагаар хангана.

6.7 Эмнэлгийн мэргэжилтний гэрээний биелэлтэд хяналт тавина.

Долоо. Эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг

7.1 Үйлчлэх хүрээний хүн амд төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээг чанартай үзүүлнэ.

7.2 Эмнэлгийн мэргэжилтний хөгжил, төгсөлтийн дараах сургалтын зөвлөлөөр батлагдсан төлөвлөгөөний дагуу орон нутгийн 2-оос доошгүй мэргэжилтнийг ажлын байранд нь сургана.

7.3 Үйлчлэх хүрээний хүн амын дунд тухайн мэргэжлийн чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэг хийж, шаардлагатай тохиолдолд хяналтанд авна.

7.4 Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт бусад дүрэм журмыг чанд баримтлан ажиллана.

7.5 Гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг талуудаас шаардана.

7.6 Гэрээний биелэлтийн талаар санал хүсэлтээ Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт гаргана.

Найм. Талуудын хүлээх хариуцлага

8.1 Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой маргаантай асуудал үүсвэл талууд харилцан тохиролцож маргааныг шийдвэрлэнэ.

8.2 Талууд тохиролцоонд эс хүрвэл маргааныг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

8.3 Гэрээний хугацаанд энэхүү гэрээний 10.3-аас бусад үндэслэлээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан бол гэрээ ёсоор олгогдсон урамшууллын мөнгө, бусад зардлыг гэрээт эмч нөхөн төлнө.

Ес. Санхүүжилт

9.1. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд олгох урамшуулал төрийн санхүүжилтээр шийдэгдэнэ. Их эмчид сар бүр 1.500.000 төгрөг, сувилагчид сар бүр 1.000.000 төгрөг олгоно.

9.2. Урамшууллыг дараах хуваарийн дагуу олгоно. Орон нутагт анх явахад 30% -ийг; Гэрээний хугацаа дуусаж, гэрээг дүгнэсний дараа 70% -ийг олгоно.

Арав. Гэрээ цуцлах

Дараахь тохиолдолд гэрээ цуцална.

10.1 Эмнэлгийн мэргэжилтний гэрээ байгуулснаас хойш нэг сарын дотор ажлаа эхлээгүй.

10.2 Эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн алдаа гаргаж хүний эрүүл мэндийг хохироосон, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн нь зохих байгууллагаар тогтоогдсон.

10.3 Эмнэлгийн мэргэжилтэн гэрээний хугацаа дуусахаас өмнө эрүүл мэндийн байдлаас шалтгаалан гэрээгээ биелүүлэх боломжгүй болсон.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД / /

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН..... / /

....АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА..... / /

....АЙМГИЙН ЭМГ-ЫН ДАРГА..... / /